



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/36/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204

Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj @audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	6
2.1. Оршил	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.11 № 34

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519516

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ





2.1. Оршил

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Г.Бадраа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалт, төлөвшсөн иргэн болгож хүмүүжүүлж, эрүүл монгол иргэн болгон хүмүүжүүлэх”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Асoulus” программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 315,920.8 мянган төгрөгөөс тооцон 6,318.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8,927.6 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 1-р цэцэрлэг нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,727.0 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт “үндсэн хөрөнгө”-ийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	240.0	-	-240.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	95,171.6	97,304.9	2,133.3
Үндсэн хөрөнгө	714,493.7	824,220.7	109,727.0
Нийт хөрөнгө	812,440.4	923,935.2	111,494.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	408,530.1	408,530.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	812,440.4	923,935.2	111,494.8

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн үлдэгдэл өссөн хөрөнгө оруулалт хийгдсэнээс шалтгаалжээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 121,815.6 мянган төгрөгийн цэцэрлэгийн их засвар, 5,716.4 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 3,287.0 мянган төгрөгөөр тавилга, эцэг эхийн хандиваар 1,500.0 мянган төгрөгийн гадна тогломоор нэмэгдсэн байна. Хуримтлагдсан элэгдлийн дүн нь 103,720.7 мянган төгрөгөөр буурч нийт дүнгээрээ 109,727.0 мянган төгрөгөөр өссөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	0	198.0	-198.0	100
Нийт дүн	0	198.0	-198.0	100

Цэцэрлэг нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлаагүй байна.



Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 304,357.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 285,895.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 18,462.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,620.2 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,500.0 мянган төгрөг, нэмэлт орлогоор 198.0 мянган төгрөг, нийт 3,698.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс ном хэвлэхэд 3,500.0 мянган төгрөгийг бичиг хэрэгт, 198.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 15,021.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага, 500.0 мянган төгрөгийн санхүүгийн тайланд залруулга хийж ажиллаа.

1. Тайлант хугацаанд хийсэн нийт 15,021.2 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд бүрэн байршуулсан байна.



2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	97 946 740,68	99 714 551,12
33	АВЛАГА	240 000,00	00,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	240 000,00	00,00
35	БАРАА МАТЕРИАЛ	97 706 740,68	99 714 551,12
351	Түүхий эд материал	00,00	153 900,00
35130	Эм боох материал	00,00	153 900,00
354	Хангамжийн материал	97 706 740,68	99 560 651,12
35410	Бичиг хэргийн материал	1 208 124,50	1 058 524,50
35420	Аж ахуйн материал	1 327 000,00	1 196 200,00
35470	Бусад хангамжийн материал	95 171 616,18	97 305 926,62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	714 493 719,28	824 220 748,44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	714 493 719,28	824 220 748,44
392	Биет хөрөнгө	581 768 719,28	691 259 248,44
39201	Барилга, байгууламж, орон сууц	548 911 614,00	670 727 279,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-19 832 126,44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57 273 809,50	64 640 189,50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44 031 905,62	-46 896 003,90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32 251 015,80	38 268 015,80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30 986 964,52	-31 891 055,68
39214	Бусад үндсэн хөрөнгө	20 358 000,00	20 358 000,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2 006 849,88	-4 115 049,84
393	Биет бус хөрөнгө	132 725 000,00	132 961 500,00
39301	Програм хангамж	1 015 000,00	1 251 500,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 015 000,00	-1 015 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	132 725 000,00	132 725 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	812 440 459,96	923 935 299,56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	812 440 459,96	923 935 299,56
51	Засгийн газрын хувь оролцоо	812 440 459,96	923 935 299,56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	408 530 130,97	408 530 130,97
51101	Өмч: - төрийн	408 530 130,97	408 530 130,97
512	Хуримтлагдсан үр дүн	-61 792 660,93	49 702 178,67
51210	Өмнөх үеийн үр дүн	-61 792 660,93	-61 792 660,93
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	111 494 839,60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	465 702 989,92	465 702 989,92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	812 440 459,96	923 935 299,56



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	335 203 873,53	446 379 745,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43 751 973,53	138 324 045,00
120	Нийтлэг татварын бус орлого	27 405 070,53	6 355 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27 405 070,53	6 355 000,00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхуужих	24 185 180,53	00,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3 219 890,00	6 355 000,00
121	Хөрөнгийн орлого	16 346 903,00	131 969 045,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	16 346 903,00	131 969 045,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 500 000,00	22 160 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхуужих	289 951 900,00	285 895 600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 500 000,00	3 698 000,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00,00	2 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1 500 000,00	1 500 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааныг хүрээнд ойл болсон нэмэлт орлого	00,00	198 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхуужих	00,00	18 462 100,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	00,00	18 462 100,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	315 920 803,68	334 884 905,40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315 920 803,68	334 884 905,40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285 561 734,68	332 451 384,09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167 641 755,38	206 684 403,00
210101	Үндсэн цалин	151 978 649,38	172 198 562,00
210102	Нэмэгдэл	6 346 090,00	17 134 248,00
210104	Урамшуулал	9 317 016,00	17 351 593,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20 231 700,00	26 023 485,69
210201	Тэтгэврийн даатгал	13 487 800,00	17 755 685,69
210202	Тэтгэмжийн даатгал	1 348 800,00	2 066 900,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 686 000,00	1 653 600,00
210204	Ажилгүйдлийн даатгал	337 200,00	413 400,00
210205	Эрүүд мэндийн даатгал	3 371 900,00	4 133 900,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14 279 772,00	15 921 110,00
210301	Гэрэл, цахилгаан	4 359 329,00	4 204 231,00
210302	Гүлш, халаалт	6 100 180,00	6 583 161,00
210303	Цэвэр, бохир ус	3 820 263,00	5 133 718,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 139 808,00	8 484 819,56
210401	Бичиг хэрэг	523 650,00	306 100,00
210402	Тээвэр, шатахуун	575 400,00	00,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	380 905,00	827 530,00
210404	Ном, хэвлэл	261 548,00	00,00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 398 305,00	637 300,00
210408	Бараа материал акталсны зардал	00,00	6 713 889,56
2105	Нормативт зардал	50 390 600,00	47 399 550,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	242 900,00	00,00
210502	Хоол, хүнс	49 018 200,00	47 399 550,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 129 500,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 499 800,00	1 018 800,00
210604	Урсгал засвар	1 499 800,00	1 018 800,00
2107	Томилдолт, зочны зардал	115 200,00	150 000,00
210702	Дотоод албан томилдолт	115 200,00	150 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246 000,00	462 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	66 000,00	282 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26 017 099,30	26 307 215,84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 000 000,00	406 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 092 350,00	192 700,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрсгөдөл	22 924 749,30	25 708 515,84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30 359 069,00	2 433 521,31
2132	Бусад урсгал шилжүүлэг	30 309 500,00	1 107 000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16 887 800,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13 321 700,00	00,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100 000,00	1 107 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49 569,00	1 326 521,31
213303	Төвлөрүүдэх шилжүүлэг	49 569,00	1 326 521,31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	19 283 069,85	111 494 839,60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	743 276,63	00,00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	743 276,63	00,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-743 276,63	00,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	18 539 793,22	111 494 839,60



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	315 637 080,53	308 055 700,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24 185 180,53	00,00
120	Нийтлэг татварын бус орлого	24 185 180,53	00,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24 185 180,53	00,00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	24 185 180,53	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	291 451 900,00	308 055 700,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	289 951 900,00	285 895 600,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 500 000,00	3 698 000,00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00,00	2 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1 500 000,00	1 500 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00,00	198 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00,00	18 462 100,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00,00	18 462 100,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	315 637 080,53	308 055 700,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315 637 080,53	308 055 700,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285 278 011,53	305 622 178,69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	168 587 954,00	206 684 403,00
210101	Үндсэн цалин	153 242 610,00	172 198 562,00
210102	Нэмэгдэл	5 992 502,00	17 134 248,00
210104	Урамшуулал	9 352 842,00	17 351 593,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20 231 700,00	25 783 485,69
210201	Тэтгэврийн даатгал	13 487 800,00	17 515 685,69
210202	Тэтгэмжийн даатгал	1 348 800,00	2 066 900,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 686 000,00	1 653 600,00
210204	Ажилгүйдлийн даатгал	337 200,00	413 400,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3 371 900,00	4 133 900,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14 279 772,00	15 921 110,00
210301	Гэрэл, цахилгаан	4 359 329,00	4 204 231,00
210302	Түлш, халаалт	6 100 180,00	6 583 161,00
210303	Цэвэр, бохир ус	3 820 263,00	5 133 718,00
2104	Хангамж, бараа материалын зардал	26 970 085,53	5 587 070,00
210401	Бичиг хэрэг	520 500,00	594 700,00
210402	Тээвэр, шатахуун	575 400,00	00,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	380 905,00	827 530,00
210404	Ном, хэвлэл	292 350,00	3 664 840,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25 200 930,53	500 000,00
2105	Нормативт зардал	50 262 400,00	48 153 450,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153 900,00	153 900,00
210502	Хоол, хүнс	49 018 200,00	47 399 550,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 090 300,00	600 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 500 000,00	1 299 800,00
210604	Урсгал засвар	1 500 000,00	1 299 800,00
2107	Томилолт, зочны зардал	115 200,00	150 000,00
210702	Дотоод албан томилолт	115 200,00	150 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	246 000,00	698 500,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66 000,00	518 500,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3 084 900,00	1 344 360,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 000 000,00	406 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 084 900,00	938 360,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30 359 069,00	2 433 521,31
2132	Бусад урсгал шилжүүлэг	30 309 500,00	1 107 000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16 887 800,00	00,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13 321 700,00	00,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100 000,00	1 107 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49 569,00	1 326 521,31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49 569,00	1 326 521,31
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408 530 130,97	465 702 989,92	-61 792 660,93	00,00	812 440 459,96
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408 530 130,97	465 702 989,92	-61 792 660,93	00,00	812 440 459,96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408 530 130,97	465 702 989,92	-61 792 660,93	00,00	812 440 459,96
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	111 494 839,60	00,00	111 494 839,60
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408 530 130,97	465 702 989,92	49 702 178,67	00,00	923 935 299,56



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304 357 700,00	303 031 178,69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304 357 700,00	303 031 178,69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303 250 700,00	301 924 178,69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206 691 500,00	206 684 403,00
210101	Үндсэн цалин	173 512 700,00	172 198 562,00
210102	Нэмэгдэл	16 454 700,00	17 134 248,00
210104	Урамшуулал	16 724 100,00	17 351 593,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25 836 600,00	25 783 485,69
210201	Тэтгэврийн даатгал	17 568 800,00	17 515 685,69
210202	Тэтгэмжийн даатгал	2 042 200,00	2 066 900,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 579 400,00	1 653 600,00
210204	Ажилгүйдлийн даатгал	512 300,00	413 400,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 133 900,00	4 133 900,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17 162 100,00	15 921 110,00
210301	Гэрэл, цахилгаан	6 362 100,00	4 204 231,00
210302	Түлш, халаалт	7 000 000,00	6 583 161,00
210303	Цэвэр, бохир ус	3 800 000,00	5 133 718,00
2104	Хангамж, бараа материалын зардал	1 889 100,00	1 889 070,00
210401	Бичиг хэрэг	189 100,00	396 700,00
210402	Тээвэр, шатахуун	350 000,00	00,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500 000,00	827 530,00
210404	Ном, хэвлэл	250 000,00	164 840,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	100 000,00	00,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500 000,00	500 000,00
2105	Нормативт зардал	48 154 800,00	48 153 450,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153 900,00	153 900,00
210502	Хоол, хүнс	47 400 900,00	47 399 550,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600 000,00	600 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 300 000,00	1 299 800,00
210604	Урсгал засвар	1 300 000,00	1 299 800,00
2107	Томилолт, зочны зардал	150 000,00	150 000,00
210702	Дотоод албан томилолт	150 000,00	150 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура	705 000,00	698 500,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээни	525 000,00	518 500,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1361600,00	1344360,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	406 000,00	406 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	955 600,00	938 360,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1107000,00	1107000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 107 000,00	1 107 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 107 000,00	1 107 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	304 357 700,00	304 357 700,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	285 895 600,00	285 895 600,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285 895 600,00	285 895 600,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18 462 100,00	18 462 100,00
132001	Орон нутгийн төсвөөс	18 462 100,00	18 462 100,00



Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит